

САНГИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 14 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар 14/А/10

Улаанбаатар  
хот


Сургалтын төлбөрийн хэмжээ,  
зардлын норматив батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын төлбөрийн хэмжээг 150000 /нэг зуун тавин мянган/ төгрөг байхаар тогтоосугай.

2.“Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын нэг иргэнээр тооцсон зардлын норматив”-ыг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү тушаалд заасны дагуу сургалтын үйл ажиллагааны орлого, сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг тооцож, жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар /тэргүүн комиссар Р.Чингис/-д даалгасугай.



Сангийн сайд, Хууль зүйн сайдын  
 2016 оны 07 дугаар сарын 13-ны  
 өдрийн 14/АТ дугаартай хамтарсан  
 тушаалын хавсралт

ИРГЭНИЙ БОЛОН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ  
 ГАЛТ ЗЭВСЭГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ  
 СУРГАЛТЫН НЭГ ИРГЭНЭЭР ТООЦСОН ЗАРДЛЫН НОРМАТИВ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1.	Сургалтын материал, шаардагдах бичиг хэргийн зардал	1	5000	5000	
2.	Аюулгүй ажиллагааны гарын авлага	1	4500	4500	
3.	Сургалтад ашиглах сум	5.6 мм	5	2500	12500
		7.62*39 мм	5	3000	15000
		7.62*54 мм	5	3000	15000
		7.62*51 мм	5	3000	15000
		223 remongton	5	3000	15000
4.	Буудлагын бай, самбар, бууны тослох, цэвэрлэх материал	1	7000	7000	
5.	Сургалтад ашиглах анхан шатны эмнэлгийн тусламжийн материал	1	5000	5000	
6.	Тээвэр, шатахуун	1	7000	7000	
7.	Гэрчилгээ хэвлүүлэх зардал	1	5000	5000	
8.	Буудлага, дадлагад оролцогчдын өдрийн хоол	2	8000	16000	
9.	Сургагч багшийн урамшуулал*	16 цаг	8000	8000	
	<b>Нийт зардал</b>			<b>130000</b>	

\* -Нэг удаагийн сургалтыг хотод 10-аас доошгүй, хөдөө, орон нутагт 5-10 хүнийг бүрдүүлэн, 2 өдөрт багтаан зохион байгуулна.